



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 1398

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дах хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дах заалт, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Канад Улсын Лаурел сан хооронд 2015 оны 08 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан Хамтын ажиллагааны гэрээ, Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг, Канад Улсын Лаурел сан хооронд 2015 оны 10 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан Хамтын ажиллагааны гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 5 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081589



Эрүүл мэндийн сайдын
2018 оны 10 сарын 21-ны өдрийн
АУС-98 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1. Хью Макферсон Парсонс Hugh Macpherson Parsons	Канад Улс	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг Говь-Алтай Аймгийн Нэгдсэн Эмнэлэг	ГЭ0002115	Нүдний мэс засал судлал	Эмчлэх	2018.09.28-2018.10.20 /23 хоног/
2. Фрэнч Жастин Кристофер French Justin Christopher	Канад Улс	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг Говь-Алтай Аймгийн Нэгдсэн Эмнэлэг	ГЭ0002116	Нүдний мэс засал судлал	Эмчлэх	2018.09.28-2018.10.20 /23 хоног/
3. Матэн Каяалакаката Matthen	Канад Улс	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг Говь-Алтай	ГЭ0002117	Нүдний мэс засал судлал	Эмчлэх	2018.09.28-2018.10.20 /23 хоног/

	Кауалакакатха Mathen		Аймгийн Нэгдсэн Эмнэлэг				
4.	Тан Тох Вун Tan Toh Woon	Канад Улс	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг Говь-Алтай Аймгийн Нэгдсэн Эмнэлэг	ГЭ0002118	Сувилахуй судлал	Сувилах	2018.09.28-2018.10.20 /23 хоног/
5.	Ма Дебора Mah Deborah	Канад Улс	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг Говь-Алтай Аймгийн Нэгдсэн Эмнэлэг	ГС0002119	Сувилахуй судлал	Сувилах	2018.09.28-2018.10.20 /23 хоног/